

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Багахангай дүүрэг

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч буй шалтгаан
1	2	3	4	5	6
САЛБАР ЧИГЛЭЛ					
Хэсгийн дундаж хувь: 100					
1. Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
1.1	2025.02.26 109 дугаар тогтоол	Ажил амралтын цагийн зохицуулалтын тухай	Засгийн газрын 109 дүгээр тогтоолын дагуу 2025 оны 03 дугаар сарын 3, 4, 5-ны амралтын өдрүүдийг 2025 оны 03 дугаар сарын 15, 22, 29-ний өдрүүдэд нөхөн ажилласан.		
1.2	2025.01.02 02 дугаар тогтоол	“Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2025 оны хувь хэмжээг тогтоох тухай”	-		
Хэсгийн дундаж хувь: 100					
2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол					
2.1	2025.01.02 01 дүгээр тогтоол	2025 оны төсвийн нарийвчилсан хуваарийг батлах тухай	Ажил олгогчоос төлөх ЭМД-ийн шимтгэл 756.3 сая төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, суралцагсдын төлөх шимтгэл 42.3 сая төгрөг тус тус батлагдсан бөгөөд ажил олгогчоос төлөх 365.5 сая төгрөгийн шимтгэлийг хуваарилсан байна.		
Хэсгийн дундаж хувь: 100					
3. Нийслэлийн засаг даргын захирамж					
3.1	2025.01.22 А/62 дугаар захирамж	Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай	Ажлын цаг ашиглалтыг баримтлан түр эзгүй албан хаагчийг орлон, ажлын хариуцлага алдахгүй үйлчилгээ үзүүлэн ажиллаж, иргэд даатгуулагчдын хүсэлтийг чирэгдэлгүй шуурхай		

			үйлчилгээ үзүүлэх зорилгоор бусад аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрууд руу 10 хүсэлтийг дотоод сүлжээгээр дамжуулан лавлагааг авч даатгуулагчдын тэтгэврийг хугацаа алдалгүй тогтоосон. Газрын хэмжээнд тайлант хугацаанд байгууллага, иргэдээс 7 өргөдөл гомдлыг хүлээн авч холбогдох албан тушаалтнуудаар хугацаанд нь шийдвэрлүүлж, хариуг шуудангаар, албан бичгээр хүргүүлсэн.		
3.2	2024.05.31 А/630 дугаар тушаал	Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай	А/630 дугаар тушаалын дагуу байгууллагын ажлын цагийг 07:00-16:00 цагийн хооронд ажиллаж, үйлчилгээ үзүүлж байна.		
Хэсгийн дундаж хувь: 100					
4. Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал					
4.1	2025.01.20 А/16 дугаар тушаал	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Байгууллагын 1 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг 2 хувиар нэмэгдүүлэн 26 хувиар олгож байна.		
Хэсгийн дундаж хувь: 100					
5. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол					
5.1	2025.01.09 11 дүгээр тогтоол	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай	Тус тогтоолын дагуу 2.3 сая төгрөгийн 1 тоног төхөөрөмж, 5 тавилга, хэрэгслийн үнийг шинэчлэн тогтоож, данс бүртгэлд бүртгэсэн.		
5.2	2025.05.01 242 дугаар тогтоол	Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай	Тогтоолтой танилцсан бөгөөд цаашид алдаа дутагдал гаргахгүй ажиллахад хяналт тавин ажиллаж байна.		
Хэсгийн дундаж хувь: 50					
6. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол					
6.1	2025.02.07 06 дугаар тогтоол	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025	ҮОМШӨ-ний сургалт зохион байгуулах зарыг байршуулсан, өнөөдрийн байдлаар шалгарсан мэргэжлийн байгууллага байхгүй бөгөөд сургалтыг 9 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн.		

		оны төлөвлөгөө			
Хэсгийн дундаж хувь: 100					
7. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал					
7.1	2025.01.10 А/246 дугаар тушаал	Журам заавар, өргөдлийн маягтын загвар батлах тухай	2025 онд: -Өндөр насны тэтгэвэр-12 -Хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр- 6 -Тэжээгчээ алдсны тэтгэвэр- 3 Нийт- 21 Дээрх тэтгэврүүдийг тогтоохдоо тэтгэвэр тогтоох баримт бичиг бүрдүүлэх журмын дагуу бичиг баримтыг бүрдүүлэн тогтоолтыг хиж байна.		
7.2	2025.01.15 А/08 дугаар тушаал	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, шилжүүлэх тухай	Тус тогтоолын дагуу 2.3 сая төгрөгийн 1 тоног төхөөрөмж, 5 тавилга, хэрэгслийн үнийг шинэчлэн тогтоож, данс бүртгэлд бүртгэсэн.		
7.3	2025.01.06 А/01 дүгээр тушаал	НДС-н 2025 оны төсвийн хуваарь батлах тухай	Тэтгэврийн 2.2 тэрбум, тэтгэмжийн 104.3 сая, ҮОМШӨ-ний 32.4 сая, ажилгүйдлийн даатгалын сангийн 50.3 сая төгрөг, нийт 4.7 тэрбум төгрөгийн зарлагын төсөв батлагдсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар батлагдсан төсвийн хэтрэлгүй, тэтгэвэр, тэтгэмжийг олгон ажилласан.		
7.4	2025.01.06 А/02 дугаар тушаал	Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай	Үйл ажиллагааны урсгал зардалд эхний хагас жилийн байдлаар 147.3 сая төгрөгийн төсөв батлагдснаас 145.6 сая төгрөгийг зарцуулсан.		
7.5	2025.02.19 А/38 дугаар тушаал	2025 оныг Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах жил болгон зарлах тухай	Зорилтот жилийн хүрээнд 4 зорилт, хэрэгжүүлэх 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийн ханган ажилласан. Төлөвлөгөөний биелэлтийг заалт бүрээр гарган улирал бүрийн дараа сарын 15-ны дотор НДЕГ-н ШХУАЗГазарт хүргүүлэн ажиллаж байна.		
7.6	2025.01.20 А/10 дугаар тушаал	2025 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч,	Зорилтот жилийн хүрээнд хамралтыг нэмэгдүүлэхээр Татварын хэлтсээс ААНБ-н, дүүргийн статистикийн мэргэжилтнээс малчин		

		сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөө батлах тухай	болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн судалгааг тус тус гаргуулан хамтран ажилласан. Ажил олгогч: Төлөвлөгөө- 68 Гүйцэтгэл- 67 Албан журмын даатгуулагч: Төлөвлөгөө- 980 Гүйцэтгэл- 910 Сайн дурын даатгуулагч: Төлөвлөгөө- 130 Гүйцэтгэл- 91 хамруулсан байна.		
7.7	2025.02.14 A/135 дугаар тушаал	Мөнгөн урамшуулал олгох тухай	Төрийн захиргааны 1 албан хаагчид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшуулал болох 11.3 сая төгрөгийг 4 дүгээр сард олгосон.		
7.8	2025.02.10 A/15 дугаар тушаал	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай	Тэтгэврийн 2.2 тэрбум, тэтгэмжийн 104.3 сая, ҮОМШӨ-ний 32.4 сая, ажилгүйдлийн даатгалын сангийн 50.3 сая төгрөг, нийт 4.7 тэрбум төгрөгийн зарлагын төсөв батлагдсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар батлагдсан төсвийн хэтрэлгүй, тэтгэвэр, тэтгэмжийг олгон ажилласан.		
7.9	2025.02.28 A/47 дугаар тушаал	Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө батлах тухай	Зорилтот жилийн хүрээнд 4 зорилт, хэрэгжүүлэх 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийн ханган ажилласан. Төлөвлөгөөний биелэлтийг заалт бүрээр гарган улирал бүрийн дараа сарын 15-ны дотор НДЕГ-н ШХУАЗГазарт хүргүүлэн ажиллаж байна.		
7.10	2025.02.25 A/57 дугаар тушаал	Мэргэшлийн зэрэг олгох тухай	Мэргэшлийн зэргийн нэмэгдэл шинээр болон нэмэгдүүлэн олгогдох албан хаагч байхгүй.		
7.11	2025.02.25 03 дугаар албан даалгавар	Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай	2025 оны эхний хагас жилийн байдлаар санхүүгийн нийт 29 төрлийн мэдээ мэдээллэхээс 10 мэдээллийг, хүний нөөцийн нийт 60 мэдээ мэдээллэхээс 29 мэдээллийг		


			хугацаанд нь мэдээллэсэн ба мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.		
7.12	2025.03.17 А/61 дүгээр тушаал	Батлагдсан заавар, маягт хэрэглэх тухай	Албан хаагчид үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан маягтыг хэрэглэж байна.		
7.13	2025.03.21 А/68 дугаар тушаал	Хяналт, шинжилгээний ажил зохион байгуулах тухай	Хяналт шинжилгээний ажил зохион байгуулах тухай тушаалын дагуу НДЕГ-н ДАМГазарт газрын даргын гаргасан тушаалуудыг pdf хэлбэрээр хүргүүлсэн.		
7.14	2025.03.11 А/51 дүгээр тушаал	Газрын даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Тушаалтай танилцсан.		
7.15	2025.03.25 А/70 дугаар тушаал	Журам шинэчлэн батлах тухай	Журамтай танилцсан.		
7.16	2025.03.25 А/72 дугаар тушаал	Шалгалтын танилцуулгатай танилцсан, үүрэг өгөх тухай	НДЕГ-ын Хяналт шалгалтын газрын шалгалтын үүрэг, даалгаврын дагуу дараах арга хэмжээг авсан: -2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн “Журам батлах тухай” тушаалыг газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 30-ны А/03 тушаалаар хүчингүй болгосон. -2024 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тушаалыг газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/02 дугаар тушаалаар шинэчлэсэн. -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад байгаа нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 3.8 сая төгрөгийг барагдуулсан. -Нийт 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, орлогын төлөвлөгөөг 112,4 хувиар биелүүлсэн. -Архивын ажлыг сайжруулан нөхөн бүрдүүлэлтийн ажил 90 хувьтай байна. -Шалгалтаар илэрсэн зөрчлөөс 5.6 сая төгрөгийг		

			барагдуулсан ба цаашид актын барагдуулалтыг сар бүр төлүүлэхээр ажиллаж байна.		
7.17	2025.03.29 A/75 дугаар тушаал	Аудитын акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай	Нийгмийн даатгалын сангийн, санхүүгийн тайлангийн "Өлзийт экаунт аудит" ХХК-н санхүүгийн аудитын шалгалтаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан бөгөөд акт, албан шаардлага байхгүй, 2 зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд: -Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулах -Цахим дэлгүүрээс бараа материал, үндсэн хөрөнгө авах гэх зэрэг асуудлыг эхний хагас жилийн байдлаар мөрдөж ажиллаж байна.		
7.18	2025.04.03 A/48 дугаар тушаал	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай	Эхний хагас жилийн байдлаар зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу арга хэмжээ авах зөрчил илрээгүй.		
7.19	2025.04.24 A/104 дүгээр тушаал	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон гадаад улсад амьдарч байгаа иргэдийг дахин магадлах хяналт шалгалтын удирдамж батлах тухай	Тус дүүргийн иргэд Баянзүрх дүүргийн Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоолгодог.		
7.20	2025.04.23 A/98 дугаар тушаал	Сургалт зохион байгуулах тухай	Хамралт, орлого, цахим үйлчилгээ хариуцсан байцаагч 2025 оны 04 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд тус сургалтад хамрагдаж, албан хаагчдад мэдээлэл хүргэсэн.		
7.21	2025.04.24 A/105 дугаар тушаал	"Нийгмийн даатгалын байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай"	Авлигын эсрэг үйл ажиллагааны 3 зорилт, 9 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 2025.04.25-нд боловсруулан баталж, биелэлтийг НДЕГ-ын Захиргаа удирдлагын газарт 2025.06.05-нд гарган өгсөн.		
7.22	2025.04.11 A/88 дугаар	Сургалтад хамруулах тухай	Хөгжлийн менежмент сургалт судалгааны төвийн "Манлайлал ба ур чадвар", "Компаний		

	тушаал		засаглал” сэдэвт сургалтад 1 албан хаагч хамрагдсан.		
7.23	2025.05.06 А/130 дугаар тушаал	Ажлын хэсэг байгуулах тухай	Нийгмийн даатгалын мэдээллийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнтэй холбогдуулан программ хангамжид гарч байгаа алдааг засах, хөгжүүлэлт, сайжруулалт хийх тогтворжуулах, бодлогын даалгавар боловсруулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт газрын Хамралт, орлого, цахим үйлчилгээ хариуцсан байцаагч орсон бөгөөд мэдээллийг албан хаагчдад дамжуулан ажиллаж байна.		
7.24	2025.05.14 А/137 дугаар тушаал	Аудитын акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх тухай	Нийгмийн даатгалын сангийн, санхүүгийн тайлангийн “Өлзийт экаунт аудит” ХХК-н санхүүгийн аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан бөгөөд акт, албан шаардлага байхгүй, 2 зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд: -Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулах -Цахим дэлгүүрээс бараа материал, үндсэн хөрөнгө авах гэх зэрэг асуудлыг эхний хагас жилийн байдлаар мөрдөж ажиллаж байна.		
7.25	2025.04.24 А/103 дугаар тушаал	Ажлын хэсэг байгуулах тухай	Налайх дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст 3 ажил олгогчийн 7 гүйцэтгэх хуудас бүхий 85.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг албадан гүйцэтгүүлэхээр хандсан бөгөөд 3.8 сая төгрөгийн барагдуулалттай байна.		
7.26	2025.05.19 А/138 дугаар тушаал	Цахим шилжилт, их өгөгдөлд суурилсан нийгмийн даатгалын үйлчилгээний дунд хугацааны хөтөлбөр батлах тухай	Дээрх хөтөлбөртэй танилсан.		
7.27	2025.06.12	Үйл ажиллагааны урсгал	Үйл ажиллагааны урсгал зардалд эхний хагас		

	A/154 дүгээр тушаал	зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай	жилийн байдлаар 147.3 сая төгрөгийн төсөв батлагдснаас 145.6 сая төгрөгийг зарцуулсан.		
7.28	2025.06.13 A/161 дүгээр тушаал	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай	Тэтгэврийн 2.2 тэрбум, тэтгэмжийн 104.3 сая, ҮОМШӨ-ний 32.4 сая, ажилгүйдлийн даатгалын сангийн 50.3 сая төгрөг, нийт 4.7 тэрбум төгрөгийн зарлагын төсөв батлагдсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар батлагдсан төсвийн хэтрэлгүй, тэтгэвэр, тэтгэмжийг олгон ажилласан.		

ХЯНАСАН:
ДАРГА



Б.БАЯРТУЯА

БИЕЛЭЛТ БИЧСЭН:

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, АРХИВ,
ДОТООД АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Н.НАНДИН-ЭРДЭНЭ